

# ҮЛ ХАЙХРАХ ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДҮҮДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Н. Нямдорж  
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*nyamaa89@yahoo.com*

*Г. Цолмон  
Магистрант*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

*tsoogoo050505@g.mail.com*

**Хураангуй:** Энэ дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй бүхий л хүн төрлөхтөний туйлын зорилго нь амар амгалан, энх тунх, хайр энэрэлээр дүүрэн хорвоо ертөнцөд өөрөөрөө хүлээн зөвшөөрөгдөн амьдрах байдаг. Тэгвэл өөрийнхөөрөө бусдад хүлээн зөвшөөрөгдөх гэдэг бол байгаагаараа бусдад хайрлагдахын нэр буюу хүн болсныхоо хувьд эдлэх ёстой жам ёсных нь эрх юм. Та хүүхдээ төрүүлсэн л бол түүнд тодорхой энэ мэт эрхүүд үүсч байдаг. Хүүхэд бол таны өмч биш. Харамсалтай нь эцэг эхчүүд үүнийг ойлгодоггүйгээс “Би хүүхдээ яахыгаа өөрөө мэднэ” гэсэн өнцгөөс ханддаг. Хүүхдийг багаас нь шинэ тэжээлгүй хоол идүүлж, тэжээлийн дутагдалд оруулах, улиралд нь таараагүй хувцас өмсүүлэх, бэлэн бүтээгдэхүүнээр хооллох, гар утас, телевизээр аргацаах, цагт нь унтуулахгүй байх нь түүний эрүүл мэнд, амьдралын хэмнэлд насан туршид нь хор хохирол учруулж байгаа үл хайхрах хүчирхийллийн түгээмэл хэлбэр. Улмаар яриаг нь сонсохгүй байх, харилцан ярихгүй байх, нууцыг нь задруулах, доромжлох, үнсэхгүй байх гэх мэтээр үл хайхарсаар байгаа нь хүүхдийн ирээдүйн хөгжил төлөвшилд сөрөг үр дагавартайг дийлэнх эцэг эхчүүд төдийлөн анхаарахгүй байгаа нь хүүхэд бусад төрлийн хүчирхийлэлд өртөхөд хүргэж байна. Тиймээс үл хайхрах хүчирхийллийн тухай эцэг эх, олон нийтийн мэдлэг хандлагыг сайжруулахад чиглэн хүчирхийлэл болж буй шалтгааныг илрүүлж, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах шаардлагатай байна.

**Түлхүүр үгс:** Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ

## УДИРТГАЛ

Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхэд бүрд аливаа төрлийн алагчлалгүйгээр, тухайн хүүхдийн эсхүл түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл,

шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний, угсаатны буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, тусгай хэрэгцээтэй эсэх, төрсөн буюу бусад байдлаас үл харгалзан

үйлчлэх ёстой гэж заасан байдаг.<sup>7</sup> Монгол Улсын хүн ам 2017 онд 3.2 сая болсон бөгөөд нийт хүн амын 36.6 хувийг 0-18 насны хүүхэд байсан бол 2018 оны статистикийн тоон үзүүлэлтээр Монгол Улс 3,238,479 хүн амтай байснаас 38 хувийг нь 0-19 насны хүүхэд, өсвөр үеийнхэн эзэлж байгаа нь бид хүүхэд, өсвөр үеийнхнийхээ эрхийг хангаж, хөгжүүлэх нь маш чухал гэдгийг харуулж байна.<sup>8</sup>

Нөгөөтэйгүүр хүүхдийн эсрэг хүчирхийллийн нэг болох үл хайхрах хүчирхийлэл нь бусад төрлийн хүчирхийллийн үндэс суурь болж байдаг. Тиймээс үл хайхрах хүчирхийлэл даамжирснаар хүүхэд бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлт өртөх эрсдэл нэмэгдэж эхэлдэг.<sup>9</sup>

**Сэдвийн үндэслэл:** Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нэг болох үл хайхрах хүчирхийлэл нь бусад төрлийн хүчирхийллийн үндэс суурь болж байдаг. Сүүлийн жилүүдэд далд байдлаар олон арван хүүхэд гэр бүлийн хүрээнд үл хайхрах хүчирхийлэлд өртөн, хохирч байна. Тиймээс бид энэ асуудлыг илрүүлэн таслан зогсоох арга замыг судлах хэрэгтэй.

**Судалгааны зорилго:** Гэр бүлийн хүрээнд үл хайхрах хүүхдийн хүчирхийллийн өнөөгийн

байдал, шалтгааныг судлан тодорхойлох

**Судалгааны зорилт:** -Гэр бүлийн хүрээнд хүүхдийг үл хайхрах хүчирхийллийг онолын түвшинд тайлбарлах

-Гэр бүлийн хүрээнд хүүхдийн эсрэг үл хайхрах хүчирхийллийн талаарх судалгааны тайлангуудад анализ хийх

**Судалгааны хамрах хүрээ:** Гэр бүлийн хүрээнд хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртүүлсэн талаарх баримт бичиг, судалгааны тайлан тоо, баримтад анализ хийх

**Судалгааны аргазүй аргачлал:** Гэр бүлийн хүрээнд хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртүүлсэн талаарх судалгааны тайлан, албан ба албан бус баримтуудад баримт бичгийн шинжилгээ хийх

		Таамаглал	
Бие даасан хэмжигдэхүүн	хувьсах	Хамааран хэмжигдэхүүн	хувьсах
-Эцэг эх байх тухай боловсрол	байх тухай	Гэр бүлийн хүрээн дэх хүүхдийн хүчирхийлэл ба үл хайхрах хүчирхийлэл	
-Уламжлалт нийгмийн сэтгэлгээ	гэгдэх гажуудсан		
-Амьдралын нөхцөл байдал, суурийн ялгаатай байдал			
-Боловсролын байдал			
Стресст байдал			
-Өөрийн гэсэн орон гэргүй			
-Зан үйлээ хянаж чадахгүй			

**Шийдвэрлэх асуудал:** Гэр бүлийн хүрээнд хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлд өртөж буй шалтгааныг тодруулан бууруулах, урьдчилан сэргийлэх арга замыг эрэлхийлэх үйлчилгээг санал болгох

<sup>7</sup> НУБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц -1989

<sup>8</sup> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Хүн ам, 2017,2018

<sup>9</sup> НУБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа. 2006 он /23,24-р талд /

## ОНОЛ, АРГА ЗҮЙ

**Хүчирхийлэл гэдэг нь:** Өөрийн зорилгод нийцүүлэхийн тулд эрх мэдлээ ашиглан, эрхшээлдээ байлгахыг хэлнэ.

**Хүчирхийллийн төрөл нь:** бие махбодийн, сэтгэл санааны, бэлгийн, үл хайхрах гэсэн дөрвөн хэлбэртэй.

**Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхойлолт:** Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон тодорхойлолт байдаг ба тэдгээрээс хамгийн оновчтой нь:

-Эцэг эх, асран хамгаалагчдын хүүхдээ асран хамгаалах ердийн хэвийн хэм хэмжээний баталгаа алдагдсаны улмаас хүүхэд хор нөлөөг нь амсахыг хэлнэ.

-Энэ нэр томъёонд эцэг, эх эсвэл асран халамжлагчдын зүгээс үйлдсэн болон хийх ёстой үүргээ биелүүлээгүй үйлдлүүдийг хамааруулах бөгөөд тэдгээрийг гол төлөв үл хайхрах хэлбэрийн хүчирхийллээс эхлэн цаашлаад бие махбод, сэтгэл санаа, бэлгийн хүчирхийлэл гэж ангилна<sup>10</sup>.

-Өөрийн эрх мэдэл, давуу талыг ашиглан, хүүхдийг эрхшээлдээ байлгах гэсэн хүүхдийн эрхийг зөрчсөн албадлагын шинжтэй аливаа үйлдлийг хэлнэ.

-Хүүхдийн төрөлхийн болон хуулиар тогтоогдсон эрхээ эдлэх хэрэгцээг хязгаарлаж, өөрийгөө болон бусдыг хүндэтгэн төлөвших,

хөгжихөд саад болсон сэтгэл санааны, биеийн хүчний, бэлгийн харилцааны, үл хайхарч, шоовдорлох замаар сэтгэл санаа, бие махбодод гэмтэл учруулж болохуйц эсвэл учруулсан аливаа үйлдэл юм<sup>11</sup>.

### **Үл хайхрал гэж ер нь юу вэ?**

Үгийн гарал зүйгээрээ бол энэ үг нь “ялгаагүй байдал” гэсэн үг. Үл хайхрал харин ямарч хариу үйлдлийг бий болгодоггүй. Үл хайхралд хариу үйлдэл байхгүй, энэ бол эхлэл биш, харин төгсгөл юм.<sup>12</sup> Тиймээс ч үл хайхрал бол хүчирхийллийн хамийн аюултай хэлбэр. Учир нь үл хайхарсан байдлаас дандаа буруу тал услагдан дэмжигдэж, хохирогчид харин бүр илүүгээр хохирч байдаг. Үл хайхрах хүчирхийлэл нь хүүхдүүдийг өлсгөх, өвдсөн үед тоохгүй байх, цангасан үед нь шингэн уулгахгүй байх гэх мэт хүнд бэрх байдалд хариу үйлдэл үзүүлэхгүй, тэдний ганцаардалд найдварын бага ч гэсэн очийг асаахгүй байх нь тэдгээр хохирогч хүүхдүүдийг хүн төрөлхтний ой санамжаас цөллөн устгаж буйтай ижил. Тэдний хүмүүнлэг оршихуйг үгүйсгэснээр бид өөрсдийгөө хүн гэдгийг үгүйсгэж байгаа юм. Үл хайхрал бол зөвхөн зовоох биш бас шийтгэж буй хүчирхийлэл юм.

## Онолын тайлбарлал

<sup>10</sup> Хүүхдийг Ивээх Сан /Их Британи/-гийн Хүүхэд хамгаалах бодлого

<sup>11</sup> Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, тараах

материал, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц стратеги

<sup>12</sup> <https://www.trends.mn/n/8650>

### **Социологийн онолууд нь:**

учир шалтгааныг нийгмийн хүчин зүйлс болох ядуурал, нийгэм, эдийн засгийн ялгаатай байдал, нийгмээс тусгаарлагдсан байдал зэргээс улбаалан хүчирхийллийг нийгмээрээ хүлээн зөвшөөрөх нь хүүхдийг үл хайрхах, хүчирхийлэх явдлыг хүлээн зөвшөөрөхөд хүргэнэ гэсэн үзлээр хоблон тайлбарлаж болох юм. Ингэж хүлээн зөвшөөрснөөр хүүхдийн эсрэг хүчирхийлэл тэр дүндээ үл хайрхах хүчирхийлэл нь хэвийн зүйл гэсэн ойлголт хандлага нийгэмд бий болж байгааг харуулж байна.

### **Экологийн онолын үүднээс:**

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг тайлбарлах нь: Экологийн загвараар хүүхдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлөх хүчин зүйлийг бүх түвшинд буюу хохирогч хүүхэд ба түүнийг хүчирхийлэгч эцэг, эх болон асран хамгаалагч, хүүхдийн ойр дотны хүмүүс ба гэр бүл, илүү өргөн хүрээнд бол улс төр, соёлын хүчин зүйлсээр тус тус тодорхойлох ёстой гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт бий болох хүчин зүйл нь нийгэм гэж үздэг. Тухайн улсын соёл, ёс заншил, ард түмний ертөнцийг үзэх үзэл, улс төрийн бодлого ямар байгаагаас шалтгаалан хүүхдийн хүчирхийлэл тодорхойлогдоно. <sup>13</sup>

### **Социаль-когнитив онол:**

Социол-когнитив онолын үзэл баримтлал Альберт Бандурагийн (1925 онд Канадад төрсөн) үзлээр хүний ажиллагааг зан үйл, танин мэдэхүйн хүрээ, орчин зэрэг гурван хүчин зүйлийн тасралтгүй харилцан үйлчлэлд авч үзэх нь зүйтэй юм гэж тодорхойлсон харилцан шалтгаан нөхцлийн гурвалсан нөлөөлөл нь хүний зан үйлд үзүүлэх орчны нөлөөллийг үгүйсгэдэггүй. Харин орчин нь эргээд хүний өөрийнх нь үйл ажиллагааны үр дүн болж байдаг учраас хүмүүс өөрөө өөрийнхөө зан үйлд ямар нэгэн нөлөө үзүүлж чадна гэж үзжээ.<sup>14</sup> Хүчирхийллээс хүчирхийлэгч төрнө гэсэн үг байдаг билээ. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэлд байсан хүүхдүүд өөрсдөө том хүн болоод, хүчирхийлэл үйлдэх нь өндөр байдгийг судлаачид нотолсон байдаг.

### **Солилцооны онол:**

Нийгмийн солилцооны онолыг анх социологич Жорж Хоман боловсруулсан бөгөөд нийгмийн бүхий л харилцааг тайлбарлахыг зорьж байжээ. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг энэ онолоор тайлбарлахад түвэггүй байдаг. Энэ онол нь гэр бүлийн хүн ямар нэгэн хүссэн зүйлийг нь өгөөгүйгээс болж хүчирхийлэл үүсдэг гэж үзсэн. Эцэг, эхчүүд хүүхдээсээ хүмүүжилтэй байх, онц

<sup>13</sup> [www.socialwork.mn](http://www.socialwork.mn)

<sup>14</sup> О. Мягмар, Б. Цэрэнлхам, Х. Өлзийтунгалаг. Сургуулийн нийгмийн ажилтны гарын авлага

сурах гэсэн шаардлагыг хүсдэг бөгөөд үүнийг биелүүлээгүй тохиолдолд хүчирхийллийн замаар асуудлыг шийдвэрлах нь зөв гэж үздэг. Гэхдээ энэ онол нь хэт өрөөсгөл ойлголтыг тайлбарлаж байгаа хэрэг ба хүчтэй нь хүссэн зүйлээ бүтээхийн тулд хүчгүйгээ дарлаж байгааг хүлээн зөвшөөрөх хандалагатай байна.

**Нөөцийн онол нь:** Эрх мэдэл, шийдвэр гаргах боломжийг нөөц баялагтай холбон тайлбарласан. Эдийн засгийн хувьд боломжийн эрх мэдэлтэй хүмүүс нь нийгмийн нөөц баялаг багатай хүмүүсийг хүчирхийлэл хэрэглэн дарамтлах, хүмүүсийг өөрийн хяналтад оруулах замыг ашигладаг гэж Ричард Геллис хэлсэн байдаг. Энэ онолоор эцэг, эхчүүд санхүүгийн байдлаар хүүхдээ боох, би чамайг тэжээж байгаа болохоор чи миний хэлснээр хичээл номоо сайн хийж, гэр орноо цэвэрлэх ёстой гэсэн хандлагаар хандаж, хүүхдүүдийг сэтгэл санааны дарамтад оруулдаг.

**Хямралын онол:** Хямралын онолыг хямралыг даван туулахад туслах үйлчилгээний тулгуур онол болгон ашигладаг. Гэхдээ энэ онол нь бусад онолуудтай харьцуулахад томъёололын хувьд шинэ, системтэй үзэл баримтлал гэхээсээ илүү таамаглал, үзэл хандлага дээр суурилсан онол. Тийм учраас энэ онолыг онол биш “хэлэлцэгдэх шатандаа байгаа онол” гэж нэрлэдэг. (E11, 1996) Гэнэтийн цочрол, золгүй явдал, аймшигт үйл

явдлын улмаас хувь хүн, гэр бүл, бүлэг хүмүүс сэтгэл санаагаар хүчтэй унаж, тэр уналт хямралыг даван туулахгүй гэсэн мэдрэмжтэй зэрэгцэн илрэхийг кризис буюу хямрал гэнэ. (E11,1996) Хямралын онолын гол үзэл санаа нь гэнэтийн хямрал (кризис)-д орсон хүн хямралд дасан зохицох эсвэл үл дасан зохицох байдлаар хямралд хариу үйлдэл үзүүлнэ. Үүссэн нөхцөл байдал тухайн хүний даван туулах чадвараас ахадсан бол тэр хүнд стресс, хямрал илүү хүчтэй нөлөөлнө гэж үздэг.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Сүүлийн жилүүдэд хүүхдийн эрхийн хэрэгжилтэд ахиц дэвшил гарсаар байгаа билээ. Тус улс 2015 оноос хойш хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн олон хууль тогтоомж, хөтөлбөрүүдийг баталж, тогтолцооны нөр их өөрчлөлт, шинэчлэлтийг богино хугацаанд өрнүүлж байгаа боловч бодлогын уялдаа холбоогүй байдал, санхүү, хүний, институц, материаллаг баазын нөөц, чадавхи хязгаарлагдмал байдал зэргээс үүдэн тухайн чиглэлээр хууль тогтоомж, бодлогуудын үр дүнтэй хэрэгжилтийг хангахад томоохон сорил, эрсдэлтэй тулгарч байна.

Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хангах чиглэлээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын санаачилгаар 2007 онд хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлыг тодорхойлох дэлхий нийтийн судалгаа явуулсны

дүнд хүүхдийн хүчирхийлэл нь дэлхийн олон улс орнуудад нийтлэг тулгамдсан асуудал болж, үүнийг шийдвэрлэхийн тулд улс орнууд хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс хамгаалах тогтолцоог улам бэхжүүлэх шаардлагатай байгаа онцлон тэмдэглэжээ. Үүнтэй холбогдуулан 2007 оноос эхлэн анх Хүүхдийг Ивээх Сангийн санаачилгаар жил бүрийн 10-р сарын 19-ний өдрийг “Хүүхдийн хүчирхийллийн эсрэг Олон улсын өдөр”, мөн 4 сарын 30-ны өдрийг “Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг дэлхий нийтийн өдөр” хэмээн тэмдэглэж ирсэн бөгөөд хүүхдийн хүчирхийллийг бууруулахад чиглэсэн кампанит ажлуудыг өрнүүлэн тасралтгүй үйл ажиллагаагаа явуулсаар байна.

А.Батхишиг,  
Х.Өлзийтунгалаг нар гэр бүлийн хүчирхийллийг судалж, 2008 онд “Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь” нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлагадаа гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн сургалт сурталчилгаа, судалгаа, нөлөөллийн ажил, тэдгээрийг хэрхэн зохион байгуулах үйл ажиллагааны талаар судалж, тусгасан байна.

**Дараах судалгааны тайлангуудад анализ хийсэн.**

-ЯХИС, “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа. Улаанбаатар. 2017, 2018

-ЯХИС, Монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ. Улаанбаатар. 2015, 2018

-НҮБ-ын ерөнхий Нарийн Бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа

-Гэр бүлийн өнөөгийн байдалд хийсэн суурь судалгаа

**Баримт бичиг судлах аргаар:**  
Хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан нөхцөлийг тодруулах ба үл хайхрах хүчирхийллийн хор нөлөөг тодорхойлох.

Хүснэгт 1 Судалгааны ажлуудын товчлол

Гэр бүлийн өнөөгийн байдалд хийсэн суурь судалгаа дундын зөвлөлдөх уулзалтын

Судалгаа	Судалгаанд хамрагдагсдын тоо	Хамрах хүрээ	Судалгааны агуулга
НҮБ-ын ерөнхий Нарийн Бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа		Дэлхий даяар	Энэхүү судалгаанд тодорхой тоон үзүүлэлт авч үзээгүй байсан ба хүүхдийн хүчирхийллийг асрамжийн газар, ажлын байр хамт олны хүрээ гэх зэрэг бүхий л хүрээнд авч үзсэн байна.
“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа	1236	Монгол улс	“Өсвөр үеийнхний дуу хоолой” нь хүүхдүүд гэртээ, сургуульдаа, амьдарч буй нутаг орондоо өөрт нь өдөр тутам нөлөөлж байдаг асуудлаар ямар бодол, сэтгэгдэлтэй байдгийг мэдэх зорилгоор хийгдсэн хүүхдүүдээс авсан судалгаа болно.
Монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ		Монгол улс	Энэ хэсэгт монгол улсын хэмжээнд салбар бүрийн судалгаа тоо баримт нотолгоонд тулгуурлан монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлыг өргөн хүрээнд судалсан.
Гэр бүлийн өнөөгийн байдалд хийсэн суурь судалгаа дундын зөвлөлдөх уулзалтын тайлан	1000	Улаанбаатар, Архангай, Сүхбаатар, Увс, Өмнөговь	Гэрлэлт гэр бүл салалт харилцаа, үнэт зүйлс зэргийг судалсан.

тайлангын Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт хийсэн харьцуулсан судалгааны үр дүнгээс харахад Энэхүү судалгаа нь гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан болон олон нийтийн санаа бодол зэргийг судалгаанд тусгасан. Судалгаанд оролцогчдын ихэнх хувь нь гэр бүлийн хүчирхийлэл байна /95.0 хувь/ гэж үзсэн бөгөөд хүчирхийлэлд хүүхэд ихэвчлэн өртдөг гэж 57.6 хувь нь үзжээ.

Гэр бүлийн өнөөгийн байдалд хийсэн суурь судалгаа дундын зөвлөлдөх уулзалтын тайлан 1000 Улаанбаатар, Архангай, Сүхбаатар, Увс, Өмнөговь, Гэрлэлт гэр бүл салалт харилцаа, үнэт зүйлс зэргийг судалсан. НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа Дэлхий даяар Энэхүү судалгаанд тодорхой тоон үзүүлэлт авч үзээгүй байсан ба хүүхдийн хүчирхийллийг асрамжийн газар, ажлын байр хамт олны хүрээ гэх зэрэг бүхий л хүрээнд авч үзсэн.

Монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ судалгааны үр дүнд хүүхдийн эсрэг хүчирхийлэл дарамт нь олон талд учир шалтаанаас болж үйлдэгдэж байгаа ч хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй газар нь хамгийн аюулгүй байх ёстой орчин болох гэр бүлийн орчин нь байна гэж үзсэн. Жишээ нь: Кейс- 1,2 түүх бол

хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл өртүүлж байсны том жишээ юм.

**Кейс-1:** Хөвсгөл аймагт 16 настай Б-г 3 жилийн турш авга эгч нь амбаартаа хорьж тарчлааж байсан. Долоо хоногийн турш хоолгүй байсан хүү амбаарынхаа модыг онгойлгож, хажуу айлаасаа идэх юмхулгайлан идэж байгаад баригдснаар хэрэг нь илэрсэн.

**Кейс-2:** Булган аймагт хүүхдүүдээ санаатайгаар шатааж, амийг нь хөнөөсөн аймшигт хэрэг гарлаа. Булган аймгийн Орхон сумын нэгдүгээр багт оршин суух иргэн Ё гэгч нь нэг болон таван настай хоёр хүүгээ автомашиндаа суулгаж байгаад шатаасан байгаа юм. 15

**Хүснэгт 2 Гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн шалтгаан**

Судалгаа	Судалгаанд хамрагсданы тоо	Хамрагсданы хүрээ	Уламжлалт хандлага	Боловсролгүй байдал	Явуурал	Архидал	Ажилгүйдэл
"Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал сэдэвт Хан-Уул дүүрэгт хийсэн судалгааны тайлан"	280 иргэд судалгаанд хамрагдсаны 52.9 хувь нь Хан-Уул дүүрэгт хийсэн судалгааны тайлан"	Хан-Уул дүүргийн 14-р хорооны иргэд	1.1 %	12.1 %	53.2 %	34.3 %	24 %
"Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал сэдэвт Төв аймгийн Эрдэнэ суманд хийсэн судалгаа"	Судалгаанд нийт 16-64 насны эрэгтэй 33%, Төв аймгийн Эрдэнэ суманд хийсэн судалгаа	Төв аймгийн Эрдэнэ сум	3 %	17 %	34 %	86 %	45 %

**Зураг 1. 2017 онд ХИС хийсэн Өсвөр үеийнхний дуу хоолой судалгаагаар хүүхдүүд өөрийн хамгийн аюулгүй байх гэр бүлийн орчинг 22,8 хувь нь аюултай орчин гэж үзсэн тоо**

<sup>15</sup> <http://www.oloo.mn/n/901.html>



Эх сурвалж: Хүүхдийг Ивээх Сан, Өсвөр үеийн дуу хоолой судалгааны тайлан. Улаанбаатар, 2017, х.18-19

## Кейст дүн шинжилгээ хийх нь

Эдгээр кейсүүд мөн судалгаануудаас харахад олон нийт, иргэд, эцэг эхчүүдийн хувьд хүүхдийн эрхийн тухай болон хүний эрхийн тухай ойлголт хандлага байхгүй байна. Тиймээс төр засгийн зүгээс буюу төрийн анхан шатны нэгж болох дүүрэг хороо, сум багийн түвшинд ажиллаж буй хамтарсан багийн хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох үүргийнхээ дагуу урьдчилан сэргийлэх үйлчилгээний загварыг бий болгон ажиллах шаардлагатай харагдаж байна. Цаашлаад иргэний үүргээ сайн сахин биелүүлдэг хөрш айл болон бусад хүмүүс хүчирхийллийг таслан зогсоож мэдээлэх үүргээ ухамсарлан хэрэгжүүлэх дасал хэвшлийг бий болгох шаардлагатай харагдаж байна. Тиймээс хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд рүү чиглэсэн нийгэм хамгааллын бодлого, хуулийнхаа хэрэгжилтийг сайжруулан боловсруулж бодит үйл ажиллагаа төр засаг олон нийт болон эцэг эх, иргэдэд хийх хэрэгтэй байна.

## ДҮГНЭЛТ

Гэр бүл дэх зөрчил, хүүхдээ үл хайхрах хүчирхийлэл нь түгээмэл үзэгдлийн нэг болж, энэ нь даамжран, хүүхэд гэмт хэрэгт холбогдох, хүүхэд гэр орноосоо дайжих, гэмт хэрэгт холбогдох, цахим тоглоомонд донтох, мансууруулах бодис хэрэглэх, сургууль завсардах, хүмүүжлийн хувьд доголдох, эрх ашиг нь хохирох зэрэг сөрөг үр дагавар бий болсоор байна.

Хүн амд суурилсан хэд хэдэн судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 50 хувь нь буюу хоёр хүүхэд дутамын нэг нь ямар нэг хүчирхийлэлд өртдөг байна. Энэхүү асуудал нь дан ганц архидалт, ядууралтай зэрэг нийгмийн асуудлуудтай холбоотой зүйл биш юм. Тухайлбал нийгмийн орчин, хувь хүний хандлага, сэтгэлзүйн эрүүл байдал, хүний эрхийн болон хүүхдийн эрхийн тухай ойлголт мэдлэг, хүүхэд хүмүүжүүлэх арга барил гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөллөөс хамаардаг.

Тэгвэл эцэг эх, олон нийт, иргэд, хувь хүний сөрөг үзэл, хандлага, төлөвшил нь үл хайхрах хүчирхийллийн хэлбэрийг тоохгүй хэвийн зүйл мэтээр хүлээж авснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг хүндрүүлэхэд ихээхэн нөлөөлж байна гэж дүгнэж болохоор байна.

Тиймээс хүүхдийг олон төрлийн хүнд хэлбэрийн хүчирхийлэл, дарамтад өртүүлэхгүй байх үндэс бол үл хайхрах

хүчирхийллийн тухай ойлголт мэдлэгийг бүхий л орчинд түгээн дэлгэрүүлж, нийгмийн ажлын болон бусад олон нийгмийн салбаруудад урьдчилан сэргийлэх үйлчилгээг бий болгон хүүхэд, эцэг эх, олон нийт, иргэд тус үйлчилгээг үзүүлснээр хүүхдийн эсрэг бүхий л хүчирхийлээс урьдчилсан сэргийлэх боломжтой.

**Гэр бүлийн орчин дахь хүүхдийн хүчирхийллийн шалтгаануудыг бүлэглэх нь**

Нийгмийн орчин	Хувь хүн	Сэтгэлзүй
Архидалт Ядуурал Хуулийн хэрэгжилт Нийгмийн тогтсон хандлага Ес заншил Стресс бухимдал Амьдралын орчин нөхцөл	Хүмүүжил Ес суртгуун Сөрөг хандлага, Ширүүн дошгин харилцаа Ертөнцийг үзэх үзэл Буруу дадал зуршил	Зан төлөв

**Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдийг бууруулах, илрүүлэн урьдчилан сэргийлэх байдлаар ажиллахын тулд**

1. Олон нийтийг идэвхжүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл болж буйг холбогдох хороо, сум, багийнхаа хамтарсан баг болон бусад 102, 107,108 утсанд мэдэгдэх

2. Хамтарсан багаар тухайн мэдээллийн дагуу гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийн шаардлагатай тохиолдолд кейс нээх ажиллах, эрсдэлт нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлэх

3. Хүүхдэд хүүхдийн эрхийн чиглэлийн чадавхижуулах мэдлэг олгох зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалтад хамруулах, шаардлагатай

тохиолдолд сэтгэл зүйн үйлчилгээнд холбох<sup>4</sup>. Эцэг, эхчүүдийг хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэхэд уриалан дуудах, өөрийн стресс бухимдалаа тайлах шинэ арга зүйд суралцуулах, сэтгэл зүйн үйлчилгээ сургалтад хамруулах.

### НОМ ЗҮЙ

1. НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа.Улаанбаатар, 2006
2. НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн даргын хүүхдийн эсрэг хүчирхийллийн судалгаа. Улаанбаатар, 2006. Хүүхэд залуучуудад зориулсан хувилбар.
3. Нийгмийн ажлын менежмент улирал тутмын мэргэжлийн сэтгүүл.No1, No2. Улаанбаатар, 2014
4. Хүүхдийг Ивээх Сан/Их Британи/-гийн Хүүхэд хамгаалах бодлого.Улаанбаатар,2004
5. Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, тараах материал, Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэнцэх цогц стратеги.Улаанбаатар,2005
6. Сургууль,цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах замI судалгааны тайлан. Улаанбаатар, 2007
7. Гэр бүлийн өнөөгийн байдалсуурь судалгаа.Улаанбаатар, 2004
8. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн салбар дундын зөвлөгөөн,Үндсэн илтгэлийн эмхэтгэл.Улаанбаатар, 2018
9. Хүүхдийг Ивээх Сан, Монгол улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ.Улаанбаатар, 2015,2018
10. Хүүхдийг Ивээх Сан, Өсвөр үеийн дуу хоолой судалгааны тайлан. Улаанбаатар, 2017,2018
11. www.socialwork.mn
12. https://www.trends.mn/n/8650
13. http://unuudur.mn/